

# Улс төрийн нам



Та бүхнийг хичээлдээ  
амжилттай оролцохыг  
УРИАЛЖ! байна



# Улс төрийн нам

1. Улс төрийн намын үүсэл хөгжил, намын тодорхойлолт
2. Намын хэв маяг, ангилал
3. Монголын улс төрийн намын онцлог

# Улс төрийн намын үүсэл ХӨГЖИЛ

Нам гэдэг нэр томъёо нь PARS буюу “хэсэг бүлэг” гэсэн Латин үгнээс гаралтай. Намын тухай үзэл санаа нь МЭӨ 5-р зууны Грек , Ромын үеийн улс төрийн амьдралаас үүдэлтэй. Германы эрдэмтэн М. Вебер улс төрийн нам хөгжлийнхөө түүхэнд язгууртны бүлэглэл, улс төрийн клуб, олон түмний нам гэсэн гурван шатыг дамжсан гэж үздэг.







1. язгууртны бүлэглэл
2. улс төрийн клуб
3. орчин үеийн намууд

1. Язгууртнууд эд баялаг, эрх мэдлийн сонирхлоор нэгдэн бүлэглэл байгуулж, эзэн хаандаа нөлөөлөхийг оролдох, шинэ гэзар нутаг, эд баялаг эдлэх талаар өөр хоорондоо тэмцэлдэх хэлбэрээр илэрч байв. 17-р зууны 2-р хагаст Англид анхны яздгууртны, вангийн болон төрийн бүлэглэл үүссэн.



2. Улс төрийн клубын гол зорилго нь санал бодлоо чөлөөтэй солилцдог үзэл санааны урсгал. Гол нь улс төрийн бодлогын хүрээнд олон ургальч үзэл, өрсөлдөөнийг бий болгох замаар оновчтой хариу олохыг эрмэлзэж байлаа.

3. Орчин үеийн намууд үзэл санаа, зохион байгуулалтын хувьд нэгдмэл, үйл ажиллагаан нь өргөн цар хүрээтэй, олон тооны гишүүдтэй, тэднийгээ үйл ажиллагаандаа татан оролцуулдаг, улс төрийн нөлөөллийн баялаг арга хэрэгсэлтэй байдаг.

Улс төрийн нам гэж юу вэ?

Энэ асуултанд олон янзын хандлага, тодорхойлолт байгаа ч эдгээрийг дүгнэвэл, нам гэдэг нь засгийн эрхийн төлөө эрмэлзэж, улс төрийн үйл ажиллагаа явуулдаг, тодорхой зохион байгуулалттай улс төрийн байгууллага юм.



# Улс төрийн нам нь дараах онцлог шинжүүдтэй. Үүнд:

- Төрийн хэмжэнд засаглалыг авах, эсвэл түүнд оролцох зорилготой
- Өөрийн удирдах болон орон нутгийн байгууллагыг багтаасан зохион байгуулалтын бүтэцтэй
- Төрийн засаглалыг авахын тулд сонгогчдоор дэмжүүлэх эрмэлзлэлтэй
- Нэгэн үзэл суртлын үндсэн дээр сайн дураараа эвлэлдсэн зохион байгуулалттай нэгдэл холбоо байдаг явдал юм.

Намын туйлын зорилго бол сонгуульд ялж, засаг төрийн эрх мэдлийг авах, ядаж л төр засгаас гарах шийдвэрт нөлөөлөх явдал юм. Намууд өөрсдийн үзэл суртал, номлолыг үндэслэн улс орны нөхцөл байдал, олон нийтийн санаа бодлыг судалсаны үндсэн дээр улс төрийн үйл ажиллагааны ойрын зорилтуудаа тодорхойлох ажил явуулдаг

Нам нь бүтцийн хувьд:

- Намын аппарат
- Жирийн гишүүд
- Намыг дэмжигч гэсэн хэсгүүдээс  
бүрдэнэ



## Намын үндсэн үүрэг нь:

- Нийгмийн үүрэг: Нийгмийн аль нэг бүлгийн ашиг сонирхолыг илэрхийлэн хамгаалж, тэдний шаардлагыг төр засгийн түвшинд гаргаж тавьдаг
- Үзэл суртлын үүрэг: а.  
Намын үзэл сурталыг боловсруулах  
б. Баримталж буй үзэл суртлаа сурталчлан дэлгэрүүлэх, түгээх



- Улс төрийн үүрэг: төр засгийн эрх мэдлийг авахын тулд идэвхитэй үйл ажиллагаа явуулах
- Удирдлагын үүрэг: Төр засгийн эрхэнд буй намуудад хамаарагддаг. /ялангуйяа коммунист нийгэмд/ Ийм нам нь нэр төрийн төдий нам болж хувирдаг. Учир нь эдгээр намууд нь төр засгийн үйл ажиллагааг зохион байгуулж удирддаг



- ▣ Сонгуулийн үүрэг: Энэ нь сонгуульд идэвхитэй оролцох, сонгуулийн сурталчилгааны ажлыг зохион байгуулах, сонгуулийн өмнөх хөтөлбөр гаргах, сонгуулийн явцыг хянах гэх мэтээр илэрдэг байна

Гэрийн даалгавар: Улс төрийн аль нэг  
намын мөрийн хөтөлбөр цуглуулж анализ  
хийх



Анхаарал тавьсанд баярлалаа!

